

УЛААНБААТАР ХОТЫН МУЗЕЙ

2024 ОНЫ ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЙЛАН

2024 оны 12 дугаар сарын 11

Улаанбаатар хот

НЭГ. ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЛААР

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтны гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1049 дугаар захирамжаар батлагдсан “Иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх журам”-ыг мөрдөж, ERP системд бүртгэж, холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжүүлэн, шийдвэрлэлтэд хяналт тавьж, иргэнд хариу өгөх ажлыг зохион байгуулан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг эрчимжүүлэх, шийдвэрлэлтийн дундаж хугацааг зорилтод түвшинд хүргэхээр ажиллаж байна.

Улаанбаатар хотын музейд 2024 оны байдлаар иргэд, албан хаагчдаас нийт өссөн дүнгээр 20 (хорь) өргөдөл ирснийг хугацаанд нь шийдвэрлэсэн. Иргэн, албан хаагчдаас ирсэн өргөдөл хүсэлтийн шийдвэрлэлтийн дундаж хугацаа 4 хоног 19 цаг 38 минут байна.

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд дүн шинжилгээ хийж, байгууллагын захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, гарсан шийдвэр болох захирлын тушаалыг программд оруулан хавсаргаж байна.

Музейн захиргаанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх журмын дагуу өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан мэдээг байгууллагын цахим хуудсанд байршуулан олон нийтийн ил тод байдлын хуулийг ханган ажиллав.

Музейн албан хаагчдын гаргасан өргөдөл:

1. Цалингүй чөлөө хүссэн тухай

Музейн боловсролын ажилтан Г.Төгсжаргал нь БНХАУ-ын Өвөр Монголын их сургуульд магистрын ажил хамгаалах зорилгоор нэг сарын цалингүй чөлөө хүссэн. Музейн захирлын 2024 оны Б/01 дугаар тушаалаар нэг сарын цалингүй чөлөө олгов.

2. Жирэмсний болон амаржсаны амралт хүссэн тухай:

Сан хөмрөгч Б.Төгсжаргал нь 2024 оны 1 дүгээр сарын 05-ны өдрөөс жирэмсний болон амаржсаны амралт авах өргөдөл гаргасан. Музейн захирлын 2024 оны Б/02 дугаар тушаалаар Б.Төгсжаргалд жирэмсний болон амаржсаны амралт олгосон.

3. Цалинтай чөлөө хүссэн тухай:

Эрдэм шинжилгээний ажилтан О.Одсүрэн эрдэм шинжилгээ судалгааны ажлаар архивд суух 5 хоногийн цалинтай чөлөө хүссэн. Музейн захирлын 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн Б/07 дугаар тушаалаар цалинтай чөлөө олгов.

4. Ажлаас чөлөөлөгдөх тухай:

Боловсролын ажилтан Г.Төгсжаргал БНХАУ-ын Өвөр Монголын их сургуульд магистрын ажлаа хамгаалж, төгсөх шаардлагатай болсон тул ажлаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасан. Музейн захирлын 2024 оны 02 дугаар сарын 28 өдрийн Б/09 дугаар

тушаалаар Г.Төгсжаргалын хөдөлмөрийн гэрээг өөрийнх нь хүсэлтээр дуусгавар болгосон.

5. Хүүхэд асрах чөлөөг сунгах тухай:

Хүүхэд асрах чөлөөтэй байсан боловсролын ажилтан Б.Даваасүрэн хүүхдээ 3 нас хүртэл нь асрах чөлөө хүссэн. Музейн захирлын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн Б/08 дугаар тушаалаар 2025 оны 03 дугаар сарын 09-ны өдөр хүртэл сунгасан.

6. Мөнгөн урамшуулал хүссэн тухай:

Эрдэм шинжилгээний ажилтан Г.Очбаяр “Музейн үзмэртэй шууд харьцах албан тушаалтны жагсаалт”-ын дагуу сүүлийн нэг жилийн үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал авах өргөдөл гаргасан. 2021 оны Соёлын сайдын А/160 дугаар тушаал, Засгийн газрын 2022 оны 268 дугаар тогтоолын дагуу музейн захирлын 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн Б/10 дугаар тушаалаар Г.Очбаярт мөнгөн урамшуулал олгосон.

7. Боловсролын ажилтны орон тоонд дэвшин ажиллах тухай:

Үзмэр хянагч Л.Одмаа боловсролын ажилтны түр орон тоонд өөрийн хүсэлтээр дэвшин ажиллах өргөдөл гаргасан. Музейн захирлын 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн Б/11 дугаар тушаалаар Л.Одмааг үзмэр хянагчийн ажлын байрнаас чөлөөлж, боловсролын ажилтнаар томилсон.

8. Ажилд эргэн орох тухай:

Сан хөмрөгч П.Ариунаа хүүхэд асрах чөлөөтэй байсан ба ажилдаа эргэн орох өргөдөл гаргасан. Музейн захирлын 2024 оны 04 дүгээр сарын 03-ний өдрийн Б/14 дугаар тушаалаар П.Ариунааг сан хөмрөгчөөр ажилд авсан.

9. Цалинтай чөлөө хүсэх тухай:

Эрдэм шинжилгээний ажилтан Г.Очбаяр Япон улсад ажлаар явах тул цалинтай чөлөө хүссэн байна. Музейн захирлын 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн Б/16 дугаар тушаалаар цалинтай чөлөө олгов.

10. Хүүхэд асрах чөлөө хүсэх тухай

Музейн ажилтан Б.Төгсжаргал хүүхэд асрах чөлөө хүссэн. Музейн захирлын 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн Б/18 дугаар тушаалаар сан хөмрөгч Б.Төгсжаргалд хүүхэд асрах чөлөө олгов.

11. Цалинтай чөлөө хүсэх тухай.

Арга зүйч Б.Өлзийбаяр эмнэлэгт аавыг сахих цалинтай чөлөө хүссэн. Музейн захирлын 2024 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн Б/19 дугаар тушаалаар цалинтай чөлөө олгов.

12. Жирэмсний болон амаржсаны чөлөө хүсэх тухай

Музейн захирлын 2024 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн Б/23 дугаар тушаалаар нярав О.Алтантүлхүүрт жирэмсний болон амаржсаны 120 хоногийн амралт олгосон.

13. Няравын түр орон тоон ажиллах хүсэлт

Музейн захирлын 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн Б/29 дугаар тушаалаар П.Номин-Эрдэнийг няравын түр орон тоонд авч ажиллуулсан.

14. Тайлбарлагч Дэлгэрмөрөний ажлаас чөлөөлөгдөх хүсэлт

Музейн захирлын 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн Б/30 дугаар тушаалаар Д.Дэлгэрмөрөнийг ажлаас чөлөөлсөн.

15. Буцалтгүй тусламж хүсэх тухай

Нярав О.Алтантүлхүүр тархины хавангийн улмаас урт хугацааны турш эмчилгээ хийлгэх шаардлагатай болсон тул буцалтгүй тусламж хүссэн. Захирлын 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн Б/31 дугаар тушаалаар 800,000 (найман зуун мянга) төгрөгийн буцалтгүй тусламж олгосон.

16. Хүүхэд асрах чөлөө хүсэх тухай

Музейн захирлын 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн Б/34 дугаар тушаалаар нярав О.Алтантүлхүүрт хүүхэд асрах 2 жилийн чөлөө олгосон.

17. Үзмэр харгалзагч Б.Ариунцэцэгийн ажлаас чөлөөлөгдөх хүсэлт

Музейн захирлын 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн Б/38 дугаар тушаалаар Б.Ариунцэцэгийг өөрийн хүсэлтийн дагуу ажлаас чөлөөлсөн.

18. Мөнгөн урамшуулал хүсэх тухай

ЗГ-ын 2022 оны 268 дугаар тогтоол “Музейн үзмэртэй шууд харьцах албан тушаалтанд мөнгөн урамшуулал олгох журам”, Соёлын сайдын 2021 оны А/60 дугаар тушаалын хавсралт “Музейн үзмэртэй шууд харьцах албан тушаалтны жагсаалт”-г тус тус үндэслэн музейн захирлын 2024 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн Б/39 дугаар тушаалаар сан хөмрөгч П.Ариунаад сүүлийн нэг жилийн үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгосон.

Музейд ирсэн иргэдтэй холбоотой өргөдөл, хүсэлт, гомдлын шийдвэрлэлт нь:

1. Иргэн С.Баяртогтох, С.Цэцэгмаа нараас гаргасан хүсэлт


БНМАУ-ын урлагийн гавьяат зүтгэлтэн, уран сийлбэрч Самдангийн Сэнгээгийн тус музейд хадгалагдаж байгаа “Түүхэн Улаанбаатар”, “Зааны соён ясан хөөрөг”, “Орос Монгол цэрэг” гэсэн гурван бүтээлийг “Бөхийж үзээгүй ноён нуруу” үзэсгэлэнд оролцуулах, зөөж, тээвэрлэх зөвшөөрөл хүссэн.

Музейн зүгээс Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яаманд үзмэр зөөж тээвэрлэх зөвшөөрөл хүссэн албан бичгийг 2024 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 113 дугаар бичгээр хүргүүлж, зөвшөөрөл авсны үндсэн дээр үзмэрийг үзэсгэлэнд оролцуулсан.

2. Иргэн С.Баяртогтох, С.Цэцэгмаа нараас гаргасан хүсэлт

БНМАУ-ын урлагийн гавьяат зүтгэлтэн, уран сийлбэрч Самдангийн Сэнгээгийн тус музейд хадгалагдаж байгаа “Түүхэн Улаанбаатар”, “Зааны соён ясан хөөрөг”, “Орос Монгол цэрэг” гэсэн гурван бүтээлийн гэрэл зураг авахыг хүссэн хүсэлтийг үндэслэн музейн захирлын 2024 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн А/30 дугаар тушаалаар иргэний хүсэлтийг шийдвэрлэв.

ТАЙЛАН ХЯНАСАН:



Б.НАРАНГЭРЭЛ
(менежер)

ТАЙЛАН ГАРГАСАН:



Д.ГАНТУЛГА
(Хүний нөөц-бичиг хэргийн
ажилтан)